

УЛСЫН ФИЛАРМОНИД ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙН ДАГУУ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

Соёлын сайдын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Улсын филармонид иргэний өргөдлийн дагуу дотоод хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд ажлын хэсэг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс Лодойн Насанбуянгийн Соёлын сайдад 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гаргасан гомдолд дурдагдсан холбогдох асуудлаар тайлбар авч, дүн шинжилгээ хийн, санал, дүгнэлт гаргах зорилгоор дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

Ажлын хэсэгт Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл, дотоод аудит, эрсдэлийн удирдлага хариуцсан шинжээч Ц.Алтанхуяг, жендэр, хүний эрхийн асуудал хариуцсан мэргэжилтэн П.Нямхүү нар ажиллалаа.

Батлагдсан удирдамжийн “Тав.Хяналт шалгалтын хамрах хүрээ, чиглэл” хэсэгт заасны дагуу өргөдөл, гомдолд дурдсан дараах асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтын үйл ажиллагаа, түүний зохион байгуулалт, гарсан шийдвэр хууль эрхзүйд нийцсэн байдал;
2. Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангасан байдал;
3. Ажлын байранд ялгаварлан гадуурхах үзэл байгаа эсэх;
4. Жендэрийн тухай хуулийн хэрэгжилт;

ДҮГНЭЛТ

Гомдол гаргагчаас ирүүлсэн гомдолд дурдсан ёс зүйтэй холбогдсон асуудлыг Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 13.3.1-т заасны дагуу Соёлын яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай ажил олгогчийн шийдвэрийг үндэслэлгүй талаарх гомдлыг Хөдөлмөрийн тухай хуулийн хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулах 154 дүгээр зүйлд заасны дагуу дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо, хүний эрх зөрчигдсөнтэй холбогдсон асуудлаар гаргасан гомдлыг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс тус тус шалгаж байна.

Иймд ажлын хэсгээс удирдамжид заасны дагуу мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалтын үйл ажиллагаа, түүний зохион байгуулалт, гарсан шийдвэр хууль эрхзүйд нийцсэн байдал, ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангасан байдал; ажлын байранд ялгаварлан гадуурхах үзэл байгаа эсэх; Жендэрийн тухай хуулийн хэрэгжилтийг гомдол гаргагчийн гомдолд дурдсан асуудлаар хязгаарлан шалгаж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Улсын Филарманийн зохион байгуулж буй Мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох шалгалт, түүний зохион байгуулалт нь Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, “Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн

байгууллагын үлгэрчилсэн дүрэм”, Төрийн албаны зөвлөлөөс баталсан Албан тушаалын тодорхойлолт, байгууллагын дүрэм, журамд нийцсэн байна гэж үзлээ.

2. Тус байгууллагаас Л.Насанбуянд цалин хөлсийг хууль тогтоомжид заасны дагуу тухай бүр олгосон, сар бүр 10-15 хувиар “ур чадварын нэмэгдэл” олгосон, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5.5.2-т заасны дагуу улирал бүр 20 хувийн “үр дүнгийн урамшуулал” олгож ажилласан үр дүнг нь урамшуулж байсан.

3. Улсын Филармони нь стратеги төлөвлөгөө, тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд батлагдсан хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан ба тухайн тоглолт бүрийн хөтөлбөрийг нэг удирдаачийн үзэмжээр бус Уран сайхны зөвлөл, Уран бүтээлийн алба хэлэлцэж эцэслэн шийдвэрлэдэг тул ажлын байранд ялгаварлан гадуурхах хандлага гарах нь харьцангуй хязгаарлагдмал. Харин тухайн байгууллагаас гомдол гаргагчийн 2 удаагийн хувийн бие даасан тоглолтод дэмжлэг үзүүлж байсан.

4. Л.Насанбуянгаас Улсын Филармонийн Захиргаа, Ёс зүйн зөвлөлд өргөдөл, гомдол гаргаж байсныг хууль, тогтоомжийн хүрээнд хугацаанд нь шийдвэрлэж байсан.

5. Гомдолд дурдсанчлан “Байгууллагын удирдлагад эмэгтэй хүмүүс байхгүй” гэсэн нь бүрэн үндэслэлтэй биш боловч Уран сайхны зөвлөлийн эмэгтэй гишүүний эзлэх хувь 28%, Захиргааны зөвлөлийн 36%, Ёс зүйн зөвлөлийн 20% нь эмэгтэй гишүүн эзэлж байгааг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу тодорхой алхам шат дараатайгаар зохистой харьцаанд хүргэхийг зөвлөж байна.

6. Л.Насанбуян нь Улсын Филармоний гоцлол дуучнаас чөлөөлөгдсөний дараа сошиал орчинд байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх мэдээлэл цацсан нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.9-т “албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон **тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойших хугацаанд** төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх” төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ зөрчсөн байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Мэргэжлийн шалгалт зохион байгуулах журамд шалгалтын комисс болон шалгуулагчийн эрхтэй холбоотой заалт, шалгалтад хамрагдах ажилтнуудад шалгалтын зар, удирдамжийг хүргэх хугацааг, мөн удирдамжид үнэлэх аргачлалыг нарийвчлан тусгах;

СОЁЛЫН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

---oOo---